

Монголд байгаа иргэд,

Герман улсын их, дээд сургуульд суралцахын тулд бүрдүүлэх зүйлүүд

I. Хэлний бэлтгэлээ хангах - Герман хэлний мэдлэгийн түвшин **B1, B2** болон **C1**

II. Материалуудаа бүрдүүлэх, шалгуулж баталгаажуулах - Дээд боловсролын хяналтын алба

III. Сургуульд өргөдлөө гаргах

I. Хэлний бэлтгэлээ хангах	II. Материалаа бүрдүүлэх, шалгуулж баталгаажуулах
<p>B1, B2 болон C1 гэж юү вэ? B1: Их, дээд сургуулийн дэргэдэх <u>коллежэд</u> суралцах эрх авах <u>хэлний мэдлэгийн түвшин</u> (<i>нэг жилийн хугацаагаар хэл болон мэргэжлийн сургалтанд хамрагдан тэнцсэн тохиолдолд их, дээд сургуульд шууд орж суралцах боломжтой болно</i>)</p> <p>B2, C1: Их, дээд сургуульд <u>шууд</u> элсэн суралцах эрхтэй болгох <u>хэлний мэдлэгийн түвшин</u></p> <p>Ямар нөхцлүүдийг бүрдүүлэх вэ? B1: 600 – 800 орчим цаг герман хэлний хичээлд суусан байх B2, C1: 1200 орчим цаг герман хэлний хичээлд суусан байх</p> <p>Хаана хэлний сургалтууд байна вэ? Герман хэлний дипломын сургалтууд: (Das Deutsche Sprachdiplom(DSD)-Schulen)</p> <p>B1:</p> <ol style="list-style-type: none">Гёте сургууль, Сүхбаатар дүүрэг 7-р хороо, 11-р хороолол, Утас: 352342Александр фон Гумбольдт сургууль, Баянгол дүүрэг, 4-р хороо, Утас: 36779018-р сургууль, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, Утас: 341079 <p>B2, C1: Гёте сургууль, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, Утас: 352342</p>	<p>Хаана, ямар байгууллагад хандах вэ? Улаанбаатар дахь Германы Элчин сайдын яамны дэргэдэх <u>„Дээд боловсролын хяналтын алба“</u>-нд хандаж материалаа шалгуулж баталгаажуулна.</p> <p>Хаяг: ХБНГУ-ын ЭСЯ, Нэгдсэн үндэстний гудамж, ш/х: 708 Утас: 99225839, Факс: (00976) 323905</p> <p>Бүрдүүлэх материалууд: М-журмаар (<i>Монголд байгаа иргэдэд хамаарах журам</i>) шалгуулах <u>өргөдлөө</u> гаргаж, дараах материалуудыг хавсаргана: үүнд:</p> <ol style="list-style-type: none">Иргэний үнэмлэхийн зургаа нааж, бөглөсөн <u>өргөдлийн маягт</u>Иргэний үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар (<i>гадаад паспорттай бол хуулбарья нь</i>)Ерөнхий боловсролын дунд сургууль төгссөн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамт<u>Их сургууль төгсөөгүй бол:</u><ul style="list-style-type: none">Их сургуульд суралцаж байгаа тухай сургалтын албаны тодорхойлолт, баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамтСурлагын дэвтэр буюу дүнгийн жагсаалтын эх бичиг, баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамт<u>Их сургууль төгссөн бол:</u><ul style="list-style-type: none">Их сургууль төгссөн гэрчилгээ, дүнгийн жагсаалтын эх бичиг, баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамтГерман хэлний <u>мэдлэгийн</u> түвшин (B1,B2 эсвэл C1) эзэмшсэн гэсэн гэрчилгээний хуулбар эсхүл бие дааж хэдий хугацаагаар суралцсан тухай тайлбар <p>Энэ байгууллагаас авах шалгалтын дараалал:</p> <ol style="list-style-type: none">Баримт бичгийг хянан үзэхЯрилцлага (зөвхөн М-журманд хамаатай) <p>Шалгалтын эцэст тус байгууллагаас юу олгох вэ? Германд суралцахад шаардагдах хэлний болон бусад боловсролыг хангасан гэсэн гэрчилгээ буюу тодорхойлолт</p> <p>Шалгалтын хураамж : 150.000 төгрөг</p>
<p>III. Сургуульд өргөдлөө гаргах</p> <p>Суралцах хүсэлтэй байгаа их, дээд сургуулиудаа сонгож, тус сургууль „Гадаад иргэдийн суралцах өргөдлийн ажил үйлчилгээний алба (uni-assist)“ -ны гишүүн эсэхийг тодруулах (Гишүүн эсэхийг дараах интернетийн хуудаснаас тодруулж болно: http://www.uni-assist.de/uni-assist.html)</p> <p>Гишүүн бол: ↓ Өргөдлөө „uni-assist“-д явуулна. өргөдлийн бүрэн, шаардлага хангасан эсэхийг „uni-assist“ шалган, хангасан тохиолдолд тухайн сургуулиудад шууд хүргүүлдэг.</p> <p>Хаяг: uni-assist e.V. Helmholtzstraße 2-9 10587 Berlin</p> <p>Гишүүн бус бол: ↓ Өргөдлөө тус сургуульд шууд явуулна.</p> <p>Өргөдөлд бүрдүүлэх материалууд:</p> <ol style="list-style-type: none">Сургууль <u>бүрт тусад нь</u> гаргасан өргөдөлЕрөнхий боловсролын дунд сургууль төгссөн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамтИх сургууль <u>төгсөөгүй бол</u> тухай сургалтын албаны тодорхойлолт, сурлагын дэвтэр буюу дүнгийн жагсаалтын баталгаажуулсан хуулбарууд, орчуулгын хамт. <u>Төгссөн бол</u> гэрчилгээ, дүнгийн жагсаалтын баталгаажуулсан хуулбар, орчуулгын хамт <u>1 хувь</u>Герман хэлний мэдлэгийн түвшин (B1,B2 эсвэл C1) эзэмшсэн гэсэн гэрчилгээний баталгаажуулсан хуулбарГерманы Элчин сайдын яамны дэргэдэх <u>„Дээд боловсролын хяналтын алба (APS)“</u>-аас олгосон гэрчилгээ (<u>эх хувь</u>)Иргэний үнэмлэхийн хуулбар (баталгаажуулах шаардлагагүй)„uni-assist“-ын үйлчилгээний төлбөр төлсөн баримт <p>Мөн өөрийнхөө и-мэйлийн болон өргөдлийн талаарх шуурхай мэдээлэлийг хүргэх хүний хаягийг бичнэ!</p>	

дэлгэрэнгүй мэдээллийг дараах интернет хуудаснуудаас авах боломжтой

http://www.ulan-bator.diplo.de/Vertretung/ulanbator/mn/10/Akademische_Pruefstelle/APS.html

<http://www.uni-assist.de/schritt-fuer-schritt-bewerben.html>